

Соёо хүрэнгийн ясан эдлэл дээрх сийлмэл зураг

Чинбатын Амарбилэг¹, Пан Лин², Эрхэмжаргалын Билгүүн³,
Загдын Батсайхан¹, Дамчаабадгарын Содномжамц⁴,
Саранхүүгийн Тэргүүнбаяр⁵, Уламбаярын Эрдэнэбат^{6,*}

Товч агуулга: Энэхүү өгүүлэл нь 2019 онд Монгол-Хятадын хамтарсан “Түйн гол” төслийн археологийн хээрийн судалгааны ажлын явцад Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт Соёо хүрэнд хийсэн малтлага судалгааны ажлын хүрээнд Хүннүгийн үед холбогдох 2-р булшнаас аргаль, янгирын сүрэг болон уул нуруу, морьтой хүн дүрсэлсэн зохиомжит нарийн сийлбэр зурагтай хоёр ясан эдлэлийн талаар өгүүлэх юм. Уг хоёр ясан эдлэлийг өгүүлэхдээ хөрш зэргэлдээх болон манай орны нутаг дэвсгэрээс олдод буй үйс, чулуу, яс болон эвэр эдлэл дээр сийлэгдсэн зураасан зураглалуудтай харьцуулан үзэж онцлог болон ялгаатай дүрслэлийг тодруулж харуулахыг зорилгоо.

Түлхүүр үг: Материаллаг соёл судлал, ясан эдлэл, хүннүгийн дүрслэх урлаг, зураасан зураг

Удиртгал

Хүн төрөлхтөн эрт цагаас гарт ойр, түгээмэл эд зүйлс буюу яс, чулуу, мод зэргээр эвлүүлэн угсармал багаж, зэвсэг хийж иржээ. Чадварлаг хүнээс авахуулаад орчин үеийн хүн хүртэлх хугацаанд өөрийн ойролцоох чулуу, яс, мод зэргийг ашиглан (Renfrew & Bahn 2020: 329–330) өөрсдийн аж ахуйн хэрэгцээг хангаж байсан бол хувьслын үе шатанд тэрхүү багаж хэрэгслээ улам боловсронгуй болгосоор иржээ. Археологийн малтлага судалгааны явцад ясан эдлэлээр төрөл бүрийн багаж хэрэгсэл болон зэр зэвсгийн зүйлсийг хийж хэрэглэхээс гадна түүхэн хөгжлийнх явцад түүн дээрээ сараачмал болон сийлсэн дүр дүрслэл хэд хэдэн удаа тохиолдож байна. Чимэглэх урлагийн талаар академич Д.Цэвээндорж тодорхойлохдоо “Чимэглэх урлаг нь гол төлөв хөдөлмөрийн багаж, сав суулга, тавилга, хувцас хунар гоёл чимэглэл зэрэг уран хийцтэй эд юмс бүтээдэг уран бүтээлийн олон салбарыг хамаардаг бөгөөд материаллаг ба оюун санааны үнэт бүтээлийг бүтээх хүрээнд давхар багтдаг” хэмээн өгүүлжээ (Цэвээндорж 1999). Хүннүгийн үеийн түүхэнд холбогдох булш оршуулга, хот суурингийн дурсгалаас хүн, амьтан, тамга тэмдэг, ургамлын хээ зэрэг нарийн дүрслэл бүхий сийлбэртэй ясан эдлэлүүд илэрсэн байдаг.

Тухайлбал, 1975 онд ЗХУ-ын археологич В.В. Свинин, Монголын археологич Н.Сэр-Оджав нарын Морин толгойд хийсэн малтлага судалгаагаар Хүннүгийн үеийн булшнаас сийлбэртэй бугын эврэн сав (Цэвээндорж нар 2016), ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсын нутаг Баргай хэмээх газарт П.Б. Коновалов Хүннүгийн үед холбогдох 1-р булшнаас мөн дээрээ дүрслэл бүхий бугын эврэн сав (Эгиймаа 2003), Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг Бага газрын чулууны Хүннү булшнаас буга, адуу, хүн, тамга тэмдэг бүхий дүрслэлтэй нумын ясан наалт (Амгалантөгс, Амартүвшин 2005), Ховд аймгийн Булган сумын Авын Хөх уулын 20-р булшнаас эмээлтэй морины дүрс бүхий ясан наалт (Төрбат 2021), Архангай аймгийн Өгийнуур сумын Тамирын Улаан хошууны 67-р булшнаас морь унасан хүний дүрс (Төрбат 2021: 221), мөн Батцэнгэл сумын Эмээлт толгойн 3-р булшнаас бод малын хавирган дээр үнэг, мод, бугын төрлийн амьтан, нохой (чоно), морь, тамга бүхий дүрслэлтэй эдлэл зэрэг илэрсэн байна. Мөн үүнтэй төстэй боловч үүлэн хээг уран нарийн аргаар сийлсэн ясан ялтас Салхитын хүннү булшнаас илэрчээ (Өлзийбаяр нар 2019). Үүнээс үзвэл Хүннүгийн үед ясан ялтас зэрэгт сийлсэн олдвор хэрэглэгдэхүүн өнөөгийн Монгол Улсын газар нутгаас цөөнгүй илэрсэн бөгөөд энэ нь тэдний соёлын салшгүй нэгэн хэсэг ажээ.

Бидний хэлэлцэх эх хэрэглэгдэхүүн бол МУИС-ийн Антропологи, археологийн тэнхим болон БНХАУ-ын Гириний их сургуулийн Археологийн тэнхимтэй хамтарсан “Түйн гол” төслийн хүрээнд 2019 оны хээрийн судалгааны үр дүнд илэрсэн ясан эдлэл юм. Тус төсөл нь нүүдэлчдийн нийгэм, эдийн

¹ МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

² БНХАУ, Баруун Хойдын их сургууль, Сиан

³ Чингис хааны өв, соёлын хүрээлэн

⁴ ШУА-ийн Археологийн хүрээлэн

⁵ БНХАУ, ӨМӨЗО, Өвөр Монголын музей

⁶ МУИС, ШУС, Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхим, МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

* Холбоо барих зохиогч: u.erdenebat@num.edu.mn
<https://orcid.org/0000-0003-0867-3691>

засаг, аж ахуй, шүтлэг бишрэлийн тухай ойлголт төсөөллийг баяжуулах, бүс нутаг дахь шилжилт хөдөлгөөн болон соёлын харилцааг тодорхой түвшинд сэргээн тодруулах, харьцуулан судлах зорилгыг тавьж ажилласан юм. Хээрийн судалгааны хүрээнд бид 2019 оны 7-8 дугаар сард Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг Соёо хүрэн хэмээх газарт Хүннүгийн үед холбогдох нийт 12 дурсгалыг малтан судалсан билээ.


Соёо хүрэн уулын Хүннүгийн оршуулгын газар нь газарзүйн байрлалын хувьд Баянхонгор аймгийн Өлзийт сумын Баянгийн ам багийн нутаг, сумын төвөөс зүүн урагш 15 км зайд, далайн түвшнээс дээш 1800 орчим метрийн өндөрт оршино. Оройгоороо хадан гарцтай өндөр уулсыг нутгийн ардууд Соёо хүрэн хэмээн нэрлэдэг бөгөөд түүний зүүн талд Харуул хүрэн, зүүн урд талд Баруун харгана хэмээх уулсын дунд оршино. Соёо хүрэн уулын урд хормойгоор том сайртай ба зүүн тийш 5 км зайд Түйн гол урсана. Оршуулгын газар байрлалын хувьд уулын урд талын тэгш дэвсгэр дээр сайр руу шахсан байдалтайгаар голоороо жалгаар тусгаарлагдсан хоёр бүлэгт хуваагдана. Хүннүгийн оршуулгын газар нь сайрын хойд талын уулын хормой хүртэл үргэлжлэх дэвсгэр дээр оршино. Уг газарт нийт 90 гаруй булш тархсан бөгөөд ихэнх хэсэг нь баруун талын жалганы зүүн талаар байх ажээ. Нийт малтан судалсан Хүннү булшнууд нь ихэнх нь дунд зэргийн чулуугаар хоёроос гурван үе чулууг үелэн дугуйруулсан ба голдоо чулуугүй байна. Малтан судалсан дурсгалууд дундаас 2-р булшнаас нэгэн өвөрмөц хэрэглэгдэхүүн гарсан ба булшны тодорхойлолт дараах хэсэгт сийрүүлэв.

Эх хэрэглэгдэхүүн

2-р булш. Газрын өнгөн хөрсөн дээр цагариг хэлбэрийн хавтгай чулуун дараастай. Малтлагын 1-р үед өнгөн хөрсийг цэвэрлэхэд 610 см голчтой цагариг хэлбэрийн дугуй чулуун дараас мэдэгдэв. Малтлагын 2-р үед булшны чулуун дараасыг авч доош малтахад булшны төв хэсгээс баруун хойд зүгт чиглэсэн 280х160 см хэмжээтэй булшны нүхний толбо болох зөөлөн бор шороон хөрс илрэв. Малтлагын 3-р үед хавтгай чулууг эгнүүлэн өрсөн 200 см урт, 65-85 см өргөн, 55 см өндөртэй чулуун хашлага илрэв. Хашлага чулууны дотор талд модон авсыг байрлуулжээ. Авсны хадгалалт харьцангуй сайн бөгөөд баруун хойш 26 хэмд чиглэсэн 180 см урт, 55 см өргөн, 35 см өндөр. Авсны зүүн болон баруун талын хананаас харахад гадна талаас нь авсны тагнаас 12 см, ёроол хэсгээс 18 см зайд буюу гол хэсэгт голдоо товгортой дугуй, гурвалжин хэлбэрийн төмөр чимэглэлийг нэг эгнээнд цувуулан хадаж тогтоож чимэглэсэн бололтой. Булшны нүхний зүүн хойд хэсгээс хүрэл толины хагархай, баруун хэсгээс хүний эрүүний яс, баруун тийш харуулан хаясан бүтэн шавар ваар, хойд хэсгээс хүний дунд чөмөг, шаант яс, томсон дээсний тасархай зэрэг зүйлс илрэв. Хойлгын хэсэгт нийт 4 үхэр, 12 хонь дагалдуулан оршуулсан бөгөөд үүнээс чулуун хашлаганы зүүн хойд буланд толгойг баруун хойд зүгт харуулан давхарлан тавьсан үхрийн толгойн яснууд бяцарч эвдэрсэн боловч анхны байрлалаа алдаагүй ажээ. Бусад яснууд хөндөгдөж бөөгнөрсөн байдалтай бөгөөд эдгээр ясан дотроос ясан савх, дотор талдаа



Зураг 1. Соёо хүрэн уул



Зураг 2. Баянхонгор аймгийн Өлзийт сумын өндөршлийн зураг

чий будагтай 18 см голчтой таваг, ухмал модон цар, төмөр эдлэл, шавар ваарын хагархай, дээрээ уул, ой мод, янгир, аргаль, морьтой давхиж буй хүн дүрсэлсэн нумын ясан наалт зэрэг олдвор илрэв. Авсны төв хэсгээс хүний гавлын яс, зүүн хэсгээс дунд чөмөг, сүүжний яс, харин авсны гадна талаас бариул нь хугарсан төмөр шанага илэрсэн. Оршуулгын нүхний нийт гүн 240 см.

Ясан эдлэл дээрх дүрслэл

Нэгдүгээр ясан эдлэл: Уг ясан эдлэлийн зүүн доод болон баруун дээд хэсэгтээ гэмтэж алга болжээ. Уг ясан эдлэлийн хэмжээний хувьд 16,3 см урт, 2,3 см өргөн, 0,1 см зузаантай. Тус ясан наалтын дүрслэлийн агуулгын хувьд хангай, говийг хослуулан дүрслэн харуулахыг эрмэлзсэн байна. Уг ясан эдлэлийн дүрслэлийг хоёр хэсэгт ангилан авч үзвэл зүүн хэсгийн эмтэрхий хэсэгт уул байсан гэж үзвэл нийт дөрвөн уулсын энгэр бэл, оройгоор арван хоёр тооны навчит



Зураг 3. Соёо хүрэн 2-р дурсгалаас илэрсэн 1-р ясан эдлэл

моддыг (хар мод байж болох юм) дүрсэлжээ. Харин баруун талын хэсэгт уулсыг дүрслэхдээ намхавтар уулын орой хэсгийг нарийн зураасаар уртааш нь ойр ойрхон зайтайгаар сийлж уулын орой хэсгийг заагласан байдалтай дүрслсэн байгаа нь уулын орой хэсгийг хадархаг аль эсвэл цавчим өндөр хэмээн харуулахыг зорьсон бололтой. Харин мөлгөр оройтой уулсын энгэр бэлээр нь зургаан тооны янгирыг (*Sariga sibirica* Pallas) модтой уулын зүгт тэмүүлэн давхиж буйгаар дүрсэлжээ. Тус дүрслэл нь нарийн хийцтэй бөгөөд ялангуяа янгирын сүргийн маш нарийн ур хийц сайтайгаар дүрсэлсэн байна.

Хоёрдугаар ясан эдлэл: Тус эдлэл нь нийт гурван хэсэг болон хуваагдсан боловч бид тухайн ясан эдлэлийн хугарсан хэсгүүдийн хэлбэр байрлалыг нь сэргээж чадсан билээ. Хэмжээ 8 см урт, 2,4 см өргөн, 0,1 см зузаан. Ясан эдлэлийн зүүн хэсэгт тохом дэвсэж морь хөлөглөж байгаа хүнийг дүрсэлсэн ба морьтны нүүрний хэсэг балартсан, дээл хувцасны зүүн ханцуй нь морьт харваачид амар байдлаар сур бүхий зүйлээр боосон, гутал нь урт түрийтэй хоншоор хэсгийг шовх хэлбэртэйгээр дүрсэлжээ. Үүнээс зүүн зүгт морьтныг дүрсэлсэн бололтой ч унаач дүрсэлсэн хэсэг нь эвдэрч алга болжээ. Морины хувьд тохом, хазаар зэрэг хэрэглэлтэйгээр цойлж байгаагаар дүрсэлжээ. Баруун хэсэг нь харьцангуй бүтэн хадгалалттай ба нүүрэн хэсэгт гурван аргаль (*Ovis ammon*) дүрсэлснээс 2 нь бүтэн үлдсэн ба мөлгөр оройтой уулын оройн хэсгээр давхиж буйгаар дүрсэлж цаад талд нь намхан уулын энгэрт навчит хоёр модыг, цаана нь зургаан тооны навчит модыг дүрсэлжээ. Уулын орой хэсгийг цэглэх арга техникээр сийлбэрлэн дүрсэлжээ. Найман тооны хар мод бололтой дүрслэлийг дов, өндөр уулын орой хэсгээр дүрсэлсэн бөгөөд зүүн тийш гурван аргаль дүрсэлсэн байх бөгөөд түүний хоёр нь бүтэн үлджээ.

Дээр дурдсан хоёр ясан эдлэл нь дүрслэл болон зохиомжийн хувьд ижил төстэй тал байгаа хэдий ч дүрсэлсэн үйл явдлын хувьд харьцангуй ижил

болон ялгаатай талууд байгаа нь ажиглагдаж байна. Түүнчлэн бид тус ясан эдлэлийг хийсэн арга зүй болон технологийн талаар доор авч үзлээ.

Ясан эдлэл хийх арга зүй


Хүннүгийн үед хамаарах хээ чимэглэлийг зураасан урлалын арга зүйгээр судлах нь чухал юм. Ясан эдлэлийн хийх арга зүйн тухай тусгайлан авч үзсэн судалгаа одоогоор манай улсад хараахан үгүй байна. Харин Баруун Сибирийн ясан урлал, НТӨ II мянганаас НТ II мянганы эхний хагас хэмээх бүтээлд 100 археологийн дурсгалаас 3000 орчим ясан эдлэлийг төрөл арга зүйн ангилал, түүхий эдийн судалгаа, ул мөрийн шинжилгээ (traceology), туршилтын археологи (experimental archaeology), үйлдвэрлэлийн цаг хугацааны ангилал, үйл ажиллагаа нийгмийн үүргийн шинжилгээ (processual archaeology) зэрэг арга зүйгээр судалжээ (Бородовский, 1997). Дээр дурдсан судалгаанаас үзэхэд мэдээж амьтны ясыг хэрэглэж байгааг тодруулах нь чухал бөгөөд мөн үйл явц буюу ясаар үе шаттайгаар үйлдвэрлэх тухайн үйлдвэрлэлийн үйл явц нь эртний урлаачдын эд материал бэлтгэх арга ажиллагааны зэргийн талаар тодорхой мэдээлэл өгч хамгийн гол зүйл гэж хэлж болох ямар зориулалтаар, хэнд? яаж? ямар утга агуулгатай зэргийг тодруулж болох юм. Арга зүйн хувьд 3 үе шаттайгаар судлах нь илүү тохиромжтой.

1. Түүхий эд буюу ямар амьтны аль хэсгийн ясыг ашиглаж буйг,

2. Үйл явц (processual) судлах буюу амьтны аль хэсгийн ясаар, ямар арга техник ашиглаж дүрслэх талбайг бэлдэж, сийлбэр хийж буйг,

3. Үүрэг зориулалт болоод утга агуулгыг тайлбарлах гэсэн үе шаттайгаар судалбал тохиромжтой мэт санагдана.

Түүхий эд: Түүхий эдийн гарлын хувьд хугарч эмтэрсэн хэсгээс үзэхэд амьтны гаралтай урт яс бололтой. Ясан эдлэл нь эртний хүн амын хоол



Зураг 4. Соёо хүрэн 2-р дурсгалаас илэрсэн 2-р ясан эдлэл

хүнсний уламжлал түүхтэй салшгүй холбоотой билээ. Нүүдэлчин ард түмэн байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалд зохицон мал аж ахуйд түшиглэн өвөрмөц соёл иргэншлийг цогцлоосон билээ. Хүннү нарын аж ахуйн тухай дурдсанаар тэд “Тэдний малын олонхи нь адуу, үхэр, хонь, ямаа юм. Эгтгээд мал гэвэл тэмээ, илжиг, луус, зуайги, таоту, таньси юм” хэмээн тэмдэглэгдсэн байна. Мөн тэднийг ан ав хийж өрхийн хэрэгцээ, цэргийн хоол хүнс, худалдаа арилжаа зэргийг хийдэг байсан тухай ч тэмдэглэл байна (Сүхбаатар 2023: 31–32).

Нүүдэлчдийн хоол хүнсний уламжлалд ан ав, мал амьтныг бүхий л эдийг аль болох хаягдалгүйгээр ашигладаг билээ. Үүний нэгэн ажил ан гөрөө болон мал аж ахуйг гол бүтээгдэхүүн болох малын махыг хүнсэндээ хэрэглэж, үүнээс үлдсэн малын ясыг өөрсдийн ахуйд нийцсэн багаж хэрэгсэл, гоёл чимэглэл, зэр зэвсэг, адуу малын тоног хэрэгсэл, тоглоом наадгайн зүйлс, хөгжмийн хэрэгсэл зэргийг хийж ашигладаг байжээ. Цаашид эл сэдвийг үргэлжлүүлэн судлахад ясан эдлэлийг ямар амьтны ясаар хийж буйг судлах нэн шаардлагатай. Макро судалгаагаар ясыг амьтны яс, эвэр, зааны яс зэргийг тодруулах боломжтой бол микро түвшний судалгаагаар эдийн бичил бүтцийг таних, илүү лавшруулан судлахад “ZooMS” буюу пептидийн масс спектрометрийн судалгааг ашиглан амьтны төрөл зүйлийг тодруулах, мөн ДНХ-ийн дараалал тодорхойлох (aDNA sequencing), хими болон изотопийн шинжилгээгээр түүхий эдийн гарал, солилцоо, боловсруулалтын онцлогийг тодруулах боломжтой бөгөөд тус судалгаанууд ясан эдлэлийн судалгаанд нэн шаардлагатай билээ.

Үйл явц (processual): Ясан эдлэлийг судалж буй эрдэмтэд дийлэнхдээ үйлдвэрлэх арга зүй, үүрэг зориулалтыг судалдаг. Энэ талаар судлаач Paul Bahn, Colin Renfrew нар “... Эдгээр түүхий эдлэл хэрхэн олдсон болохыг тогтооход хүндрэлгүй... тул археологичид ихэвчлэн үйлдвэрлэлийн арга ба зориулалт дээр төвлөрдөг” гэжээ (Renfrew & Bahn, 2020: 329). Соёо хүрэнгийн ясан эдлэлийг элэгдлийн арга зүйгээр судлахад магадгүй чулуу, арьсаар зүлгэж, сийлбэр хийх талбайг хавтгайлан бэлдсэн нь тодорхой харагдана. Хүннүгийн үеийн урчууд яс, эврийг зэргийг усанд чанах, жигнэх болон дэвтээн бэлдэж ажиллахад амар болгож, зорох, хусах, цуулах зэргээр хэрэгцээт хэлбэрт оруулан хэрэглэж байсан тухай олон судалгааны бүтээлд тэмдэглэгдсэн байдаг (Ashby 2005: 255–262; Цэрэндагва 2017).

Ясыг бэлдсний дараа нарийн хурц үзүүртэй сийлбэрийн багаж, хутга зэргээр хэлбэрт оруулж, холтослож авах замаар сийлбэрийг хийдэг байжээ. Уг ясан эдлэлийг нүхэлсэн байдлаас авч үзвэл тус эдлэл нь нум аль эсвэл ямар нэгэн хэрэгсэлд наах, сур зэргээр холбох үүрэг зориулалтаар ашиглаж байсан бололтой. Энэ төрлийн эдлэлүүд Хүннү

болон эртний нүүдэлчдийн үед өргөн хэрэглэгддэг байжээ (Билгүүн 2023). Тухайн дүрслэл нь эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзлийг илэрхийлсэн зүйл юм. Соёо хүрэнгийн ясан эдлэлийн сийлбэрийн арга зүйн хувьд нэг талыг нь хагас налуу байдлаар хурц иртэй багажаар зүсэх бөгөөд зураасан урлалын хүрээ хэсгийг нь эгц дээрээс нь зүсэх, мөн хоёр талыг нь эгц дээрээс нь зүсэж хүрээ үүсгэсний ар дээр голын хэсгийг нь хагас налуу байдлаар зүсэн авч бүтээжээ.

Үүрэг зориулалт, бэлгэдэл: Тус сийлмэл зураг нь ан гөрөө, амьтны загварт урлагийн зураасан урлалын аргаар дүрсэлсэн ба цэрэг дайны байдлыг биш харин ан гөрөөний тухай дүрсэлсэн ажээ. Ан авын тухай “МЭӨ 160 онд Модун шаньюй 100000 морьт цэрэгтэй их ав... МЭӨ 80 хэдэн оны мэдээгээр булга, үнэг дорго, зэрэг зүйлээр мөн худалдаа хийж байсан тухай ...” сурвалжуудад тэмдэглэгдсэн байдаг (Сүхбаатар 2023: 40). Дээр буй дүрслэлээс авч үзвэл тухайн урлаач нь ан ав, хүрээлэн буй орчин, амьтны хөдөлгөөн, зан араншин, анатомийн хувьд бодит, гарамгай дүрсэлсэн нь харагдаж байна. Мөн түүнчлэн морьтон, ан авлах, харвах зэргийг чадмаг дүрсэлсэн нь энэ тал дээр арвин мэдлэгтэй урлаач байсныг илтгэж байна. Цаашлаад урлаач нь нэгэн сэдэвт багтааж тус дүрслэлийг урлаж, нэгээс зураглалаас нөгөөд шилжих үйл явцыг урт шулуун зураасаар хайрцаглажээ. Утга сэдвийн хүрээнд чадамгай дүрсэлсэн тус эдлэлийг тухайн нутгийн уугуул аж төрөгч урлаач урласан хэмээн үзэх боломжтой байна.

Харьцуулсан судалгаа

Өнөөгийн Монгол Улсын нутаг дэвсгэр болон хөрш зэргэлдээх бүс нутгуудаас Хүннүгийн үед холбогдох яс, чулуу, үйс дээр сийлсэн сийлмэл зургууд олддог ба үүнийг доор жишээ болгон авч үзвэл доорх байдалтай байна.

Үйсэн эдлэл дээрх зураасан зураглал: Эртний нүүдэлчдийн хувьд Увс аймгийн Чандмань уулын 61-р булшнаас илэрсэн элдэв сараачмал дүрс бүхий үйсэн хоромсого (Цэвээндорж 1981; Эгиймаа 2003: 69), Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Бурхан толгойн 79-р булшнаас гарсан үйсэн савны дугариг таг дээрх тэрэгний дүрслэл (Төрбат нар. 2003: 241), Дундговь аймгийн Алтанширээ сумын Ширийн чулуунаас илэрсэн сийлмэл зураг бүхий үйсэн сав (Амартүвшин нар. 2021: 50–52), ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улсын Улуг-Хемийн дурсгалд геометрийн дүрслэл бүхий үйсэн сав (Кулиновская, Леус 2020: 436) зэрэг илэрч байжээ.

Чулуун эдлэл дээрх зураасан зураг: Зураасан урлал бүхий чулуун эдлэлийн хувьд бидний цуглуулсан баримт дээр одоогийн Монгол Улсын газар нутгаас Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг Их Сансар



Зураг 5. Үйсэн савны дээрх зураасан зургууд (Амартүвшин et al. 2021: 50–52)

ууланд явуулсан малтлага судалгааны явцад 1-р булшнаас богхед чулуун бүсний арал дээр сийлмэл дүрслэлтэй эдлэл гарчээ (Мижиддорж нар. 2023: 42–45). Мөн ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улсын Улуг-Хемийн оршуулгын дурсгалын АТ1/86 булшнаас 2019 онд “Хүннүчүүдийн Iphone” хэмээн алдаршсан богхед чулуун бүсний чимэг дээр зураасан урлалын аргаар сийлсэн 2 аргаль болоод дээш харсан адууг (хөрвөөж буй) дүрсэлсэн нэгэн олдвор илэрчээ (зураг 6) (Leus & Kilunovskaya 2020: 10–12).

Ясан эдлэл дээрх зураасан зураглал: Архангай аймгийн Батцэнгэл сумын Эмээл толгойн 3-р булшнаас илэрсэн бод малын хавирган дээрх сийлмэл дүрснүүд (Наваан 2018: 30–36); Төв аймгийн Алтанбулаг сумын Морин толгойн 21-р булшнаас илэрсэн аргалийн дүрс, ургамал, зураасан чимэглэл (Батболд 2011), Сэлэнгэ аймгийн Мандал сумын Бороогийн сууринаас гарсан бод малын сүүжний ясан дээр сийлсэн араатны дүрс

(Төрбат 2011: 86–93), Дундговь аймгийн Дэлгэрцогт, Адаацаг сумдын нутаг Бага газрын чулууны Алаг толгойгоос илэрсэн нумын бариулын наалтан дээр сийлсэн адуу, тамганы дүрслэл (Амгалантөгс, Амартүвшин 2005: 88–95), Дорнод аймгийн Гурванзагал сумын нутаг малтлагын Б талбайгаас илэрсэн хээ чимэг бүхий сийлбэртэй ясан эдлэлүүд (Амартүвшин нар. 2022: 39) зэргийг дурдаж болно. Харин бүсний арал дээр: ОХУ-ын Манжуураас Волга мөрний адаг хүртэлх өргөн газар нутгаас Хүннүгийн үед холбогдох зураасан зурагтай чулуун, металл, ясан бүсний арал дээрх амьтны загварт дүрслэлүүд (Кулиновская, Леус 2020), ойролцоо бүс нутгаас ОХУ-ын Кок Пашийн 6-р булшнаас илэрсэн ясан наалтан дээрх буга, янгирын дүрслэл (Бодров и др. 2003: 224), Буриадын Царамын хөндийн Хүннүгийн язгууртны 7-р булшнаас илэрсэн хүн ба морины дүрс (Miniaev & Sakharovskaya 2007: 44–56), Буриадын Баргайгаас



Зураг 6. ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улсын Улуг-Хемийн АТ1/86 дурсгалаас илэрсэн чулуун бүсний арал (Leus & Kilunovskaya 2020: 11)

илэрсэн буга, домгийн амьтны дүрслэл (Именехова 2011: 62, 63, 64), Буриадын Дэрстийн булшны эвэр дээрх гөрөөсний толгойн дүрслэл, Буриадын Дөрөөгийн (Дурен) дурсгалаас гарсан эвэр дээр мийгийн овгийн амьтны ар хэсгийг дүрсэлсэн дүрс (Давыдова 1995) илэрчээ.

Хэлэлцүүлэг

Эртний Евроазийн тал нутгийн нүүдэлчин овог аймгуудын дунд дүрслэх урлаг нь эртний түүхийн судалгаанд нэлээд өндөр байр суурийг эзэлдэг билээ. Тэр дундаа Хүннүгийн түүхэнд холбогдох булш оршуулгаас гарсан эд өлгийн зүйлс болон хадны зураг дээр сийлэн үлдээсэн урлагийн бүтээлүүд нь хосгүй юм. Хүннүчүүдийн дүрслэх урлаг болон гоо зүйн мэдрэмжийг судлахын тулд ерөнхий байдлаар нь гурав ангилан авч үздэг.

1. Хадны зураг дээр сийлэн үлдээсэн дүрслэлүүд, амьтны загварт урлагт хамаарах эд өлгийн зүйлс;
2. Зураасан зураглалтай холбоотой төрөл бүрийн үйс, чулуу, яс;
3. Эвэр дээр дүрслэгдсэн дүрслэлүүд хэмээн ангилан авч үздэг.

Энэ удаагийн судалгааны хүрээнд бид хүннүчүүдийн гурван дүрслэх урлагийн ангиллаас зураасан зураглалтай холбоотой эд өлгийг илүүд анхаарч үзлээ.

Малтлага судалгаагаар илэрсэн археологийн олдворуудыг харьцуулан шинжилбэл, Хүннүгийн үеийн дүрслэх урлаг нь материал, дүрслэлийн арга, сэдэв, хэрэглээний зориулалтын хувьд олон талтай баялаг байжээ. Үйсэн эдлэл дээрх дүрслэлүүд нь (Чандмань, Ширийн чулуу, Улуг-Хем, Бурхан толгой зэрэг) ихэвчлэн ахуй хэрэглээний эдлэл дээр хийгдсэн бөгөөд тэрэг, геометрийн хээ, амьтны дүрс зэрэг энгийн бөгөөд утга төгөлдөр сэдвийг багтаадаг ажээ. Энэ нь нүүдэлчдийн өдөр тутмын амьдрал, байгаль орчны ажиглалт, бэлгэдэлтэй холбоотой


уран сэтгэмжийг илтгэнэ. Харин чулуун эдлэл дээрх “Хүннүчүүдийн iPhone” хэмээх чулуун бүсний чимэг нь илүү нарийн зураасан урлалаар гүйцэтгэсэн бөгөөд аргаль, адуу зэрэг амьтныг хөдөлгөөнтэй байдлаар дүрсэлсэн нь тухайн урлаачийн уран сэтгэмжийг илэрхийлж буй мэт.

Гэтэл ясан эдлэл дээрх сийлмэл дүрслэлүүд (Эмээл толгой, Морин толгой, Бороогийн суурин, Бага газрын чулуу, Гурванзагал зэрэг) нь амьтан, ургамал, домгийн сэдэв бүхий дүрслэл давамгайлсан бөгөөд бүс нутгийн хэмжээнд илэрсэн Буриад, Тува, Алтайн Кок Паш зэрэг дурсгалуудтай ижил төстэй уран дүрслэлийн хэв маягийг илтгэж байна. Энэ нь Хүннүгийн соёлын хүрээний уран дүрслэл бүхий эдлэлийн нийтлэг уламжлалыг илтгэхийн зэрэгцээ, тухайн соёлын уран сэтгэмж нь зэргэлдээ бүс нутгийн соёлтой нягт холбоотой. Цаашлаад Тува, Буриадын газар нутгаас илэрсэн ясан эдлэл дээрх сийлмэл дүрслэлүүд, тухайлбал Баргай, Дөрөө, Бороогоос илэрсэн дүрслэлүүд нь амьтдыг өвөрмөц хэв шинжийг түлхүү дүрсэлсэн байгаа бол Соёо хүрэн, Тамирын Улаан хошуу, Тувагийн Улуг-Хем зэргээс илэрсэн дүрслэлүүд нь амьтныг бодит харьцаатайгаар дүрсэлсэн хэв шинж ажиглагдаж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаа хүннүчүүдийн зураасан зурагт хамаарах Баянхонгор аймгийн Өлзийт сумын Соёо хүрэн уулын 2-р дурсгалаас илэрч олдсон хоёр ясан эдлэл дээр гол анхаарлаа хандуулсан юм.

1-р ясан эдлэлийн хувьд. Харьцангуй бүтэн хадгалагдан үлдсэн боловч зүүн доод болон баруун дээд хэсэгтээ гэмтэж алга болсон. Дүрслэлийн хувьд талбайг хоёр хэсэг болгон ангилан зааглаад зүүн талын хэсэгт навчит модтой хангайг дүрсэлсэн бол баруун талд мөлгөр уулсын урдуур зургаан тооны янгирыг дүүлэн харайж буй байдлаар дүрслэн харуулсан байгаа нь Хангай – Говийг нэг талбар дээр



Зураг 7. Тамирын Улаан хошуу Б-67 дурсгалаас илэрсэн нумын ясан наалт

дүрслэхийг эрмэлзжээ.

2-р ясан эдлэлийн хувьд. Хадгалалтын хувьд ихэд гэмтэж гурван хэсэг болон хуваагдсан. Дүрслэлийн хувьд зүүн хэсэгт морьт харваачийн хоёр дүрслэл байх бол баруун хэсэг нь харьцангуй бүтэн хадгалалттай. Дүрслэлийн хувьд нүүрэн хэсэгт мөлгөр оройтой уулын орой хэсгээр гурван аргалийг давхиж буйгаар дүрсэлж цаад талд нь алсаас харагдах уулсын энгэрт навчит моддыг дүрсэлжээ.

Эдгээр хоёр ясан эдлэл дээр дүрслэгдсэн дүр дүрслэл нь одоогоор манай болон хөрш зэргэлдээх бүс нутгаас олддоод буй ясан эдлэлүүдтэй харьцуулан үзэхэд морьтны хувьд Тамирын Улаан хошууны 67-р булшнаас илэрсэн нумын ясан наалт дээрх морьт харваачийн дүрслэлтэй хамгийн ойр болж байна. Харин аргаль, янгирын дүрслэл нь эртний урлагийн түгээмэл дүрслэлээр зуржээ. Мөн бидний цуглуулсан материал дунд уулсыг энэ ясан эдлэл дээрх шиг нарийн тод дүрсэлсэн дүрслэл хараахан олддоогүй байна. Моддын хувьд жишээ болох нь Эмээл толгойн 3-р булшнаас илэрсэн ясан эдлэл дээр дүрсэлсэн модны мөчрийн үзүүрийг дээш өлийлгөж дүрсэлсэн бол бидний хэлэлцүүлж буй ясан эдлэл дээрх модны дүрслэл нь модны мөчрийг хөндлөн богино шугамаар дүрсэлж түүн дээр нарийн жижиг богино босоо цэгээр навчийг дүрсэлсэн байна. Хүннүгийн зураасан зураглалтай холбоотой бусад эд өлгийн зүйлстэй харьцуулан үзэхэд уг эдлэл нь одоогоор олддоод буй хэрэглэгдэхүүнээс хамгийн нарийн хийцтэй эд өлгийн зүйл болох нь тодорхой болж байна. Мөн энэ хоёр ясан эдлэл дээр сийлэгдсэн дүр дүрслэлийн ерөнхий утга агуулгыг нь авч үзвэл Говь-Хангайг нэгэн хавтгайд дүрслэн харуулсан байхаас гадна тухайн үеийн нүүдэлчдийн морь уналга, хувцас хэрэглэл, ан гөрөөний талаар бидэнд нэмэлт болон зарим нэгэн баримтуудыг улам бататгаж өгч буйгаар онцлог юм.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутгаас олддоод буй уг 2-р дурсгал нь байгалийн тогтцын хувьд урдуураа Түйн гол урсаж түүнээс урагш явбал говь, тал хээрийн бүс нутаг, хойгуураа хангай уул нурууд үргэлжлэх юм. Үүн дээр тулгуурлан хоёр ясан эдлэл дээр дүрслэгдсэн дүрслэл нь тухайн бүс нутгийг онцлогийг харуулсан болох нь тодорхой юм.

Эцэст нь дүгнэн үзэхэд энэхүү зураг нь Хүннүгийн ясан эдлэл дэх зураасан зургийн цуглуулгад томоохон байр суурь эзлэхийн зэрэгцээ нүүдэлчдийн морь уналга, хувцас хэрэглэл болон тэдний ертөнцийг үзэх үзэл, урлаг, гоозүйн мэдрэмж, үйлдвэрлэхүйн онцлогийг харуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн найдаж байна.

Abstract

Engraved images on bone from Soyo Khuren, Bayankhongor aimag

Chinbat Amarbileg, Pan Ling and
Erkhemjargal Bilguun, Zagd Batsaikhan,
Damchaabadgar Sodnomjamts, Terigenbayaner
(Altad Sarankhuu Terguunbayer) and
Ulambayar Erdenebat

In this paper, we are aiming to discuss two bone artefacts with a depiction of wild sheep, ibex, a mountain range, and a rider using a fine line art technique. These items were unearthed from Burial No. 2, dating to the Xiongnu period, during an excavation carried out at Soyo Khuren Mountain in Ulziit soum, Bayankhongor aimag, as part of the “Tuin Gol” Mongolian–Chinese joint expedition in 2019. In presenting these two bone artefacts, the study aims to highlight their distinctive and differing depictions by comparing it with other carved line images found in birchbark, stone, bone, and antler objects discovered in neighboring regions.

Keywords: Material culture studies, bone artifacts, Xiongnu arts, drawings

Ном зүй

Ashby, S. (2005). Bone and antler combs: towards a methodology for the understanding of trade and identity in Viking Age England and Scotland. In H. Luik, A. Choyke, C. Batey, L. Lougas (Eds.), *From Hooves to Horns, from Mollusc to Mammoth: Manufacture and Use of Bone Artefacts from Prehistoric Times to the Present* (pp. 255–262). University of Tarty. https://eprints.whiterose.ac.uk/id/eprint/11093/1/WBRG_2004.pdf?utm_source=chatgpt.com

Leus, P., Kilunovskaya, M. (2020). Recent Excavations of Xiongnu Graves on the Left Bank of the Ulug-Khem in Tuva. 16.

Miniaev, S.S., Sakharovskaia, L.M. (2007). Investigation of Xiongnu Royal Complex in the Tsaraam Valley. Part 1: The inventory of Barrow No.7 and the Chronology of the site. *Silk Road*, 5(1), 44–56.

Renfrew, C., Bahn, P.G. (2020). *Archaeology: Theories, Methods and Practice*. Thames & Hudson. <https://books.google.mn/books?id=EB42ywEACAAJ>

Амартүвшин, Ч., Одсүрэн, Д., Батдалай, Б., Бөхчулуун, Д., Камерон, Э., Адьяасүрэн, М., & Дашзэвэг, Б. (2021). Монгол-Америкийн хамтарсан “Говийн бүс нутгийн археологийн судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2021 оны тайлан.

Амартүвшин, Ч., Эрдэнэбат, У., Шалах, Г., Ханичёрч,

У., Хэнкс, Б., Жаргалан, Б., & Ангарагдөлгөөн, Г. (2022). Монгол-Израйлын хамтарсан “Дорнод Монголын хэрэмт хотын судалгаа” төслийн 2022 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн. In Д. Хатанбаатар & Л. Эрдэнэболд (Eds.), Монголын Археологи (pp. 267–271). Мөнхийн үсэг.

Амгалантөгс, Ц., Амартүвшин, Ч. (2005). Нумын наалтан дээрх сараачмал хэдэн дүрс. *Studia Archaeologica*, (III) XXII(5). https://www.researchgate.net/profile/Tsend-Amgalantugs/publication/288935336_Mongolanthropus_was_discovered_in_Mongolia/links/5845088a08ae8e63e62722a5/Mongolanthropus-was-discovered-in-Mongolia.pdf

Батболд, Н. (2011). Хүннүгийн зураасан зураг. In: Г. Эрэгзэн (Ed.), Хүннүгийн өв каталог (pp. 272–275).

Бодров, В., Васютин, А., Васютин, С. (2003). Восточный Алтай в эпоху Великого переселения народов (III–VII века).

Бородовский, А. П. (1997). Древнее косторезное дело юга Западной Сибири (Вторая половины II тыс. до н.э. - первая половины II тыс. н.э.) (В. И. Молодин (ed.); 1st ed.). Издательство института археологии и этнографии.

Давыдова, А.А. (1995). Иволгинский археологический комплекс. Том. Фонд АзийтИКА.

Именехова, Н. (2011). Костяное изделие из Могильника Баргай. In Хунну: Археология, Приосхождение культуры этническая история (pp. 60–76).

Кулиновская, М., Леус, П. (2020). Пряжки из сибирского гагата в погребениях эпохи хунну II–I вв. до н. э. В Туве. Археологические Вести, 30(1), 223–253. <https://doi.org/10.31600/1817-6976-2020-30-223-2531>

Мижиддорж, Э., Галбадрах, Б., Өнөрбаяр, Б., Эрдэнэбат, О., Цэндбаяр, Б. (2023). Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумын “Их Сансар Уул”-ын авран хамгаалах судалгаа. In: Ч. Амартүвшин, Л. Эрдэнэболд (Eds.), Монголын Археологи 2023 (pp. 42–45). Содпресс.

Наваан, Д. (2018). Хүннү судлал өнөө үед. In: У. Эрдэнэбат, Ч. Амарбилэг, Д. Содномжамц (Eds.), Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, дурсамж (1st ed., pp. 30–36). NUM Press.

Өлзийбаяр, С., Очир, Б., Уртнасан, Э. (2019). Хүннүгийн түүх соёлын судалгаа (Салхитын амны дурсгалт газар). УБ.

Сүхбаатар, Г. (2023). Монголчуудын эртний өвөг: Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган I боть (П. Дэлгэржаргал (ed.)). Соёмбо принтинг.

Төрбат, Ц. (2011). Хүннүгийн суурин, гар урлалын газрууд (Бороогийн суурин). In: Г. Эрэгзэн (Ed.), Хүннүгийн өв каталог (pp. 86–93).

Төрбат, Ц., Амартүвшин, Ч., & Эрдэнэбат, У. (2003). Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд (Хүрлийн үеэс Монголын үе) (Д. Цэвээндорж (ed.); 1st ed.). Соёмбо принтинг.

Төрбат, Ц. (2021). Тамирын Улаан хошууны 2017 оны олдворын судалгаа. - Тамирын Улаан хошууны хүннүгийн соёл. Редактор Ц.Төрбат, Э.Крюбезы. УБ.

Цэвээндорж, Д. (1981). 1981 онд Увс, Хөвсгөлд ажилласан Чандманий соёлын дурсгал судлах ангийн тайлан.

Цэвээндорж, Д. (1999). Монголын эртний урлагийн түүх.

Цэвээндорж, Д., Пэрлээ, Х., Шинэхүү, Д. (2016). 1975 оны 9 сард Төв аймгийн Баян-Өнжүүл, Бүрэн сумын нутагт 7 хоног ажилласан тухай тайлан. In: С. Чулуун (Ed.), Монголын археологи: хээрийн судалгааны тайлан (1975-1978). Боть II (pp. 77–94).

Цэрэндагва, Я. (2017). Палеолит судлалын үндэс (Д. Цэвээндорж (ed.); 1st ed.). Мөнхийн үсэг.

Эгиймаа, Ц. (2003). Хүннүгийн зураасан зургийн дурсгал. *Studia Archaeologica*, XXI(7), 69–74.

Received: Nov. 16, 2025; Revised: Dec. 9, 2025; Accepted: Dec. 20, 2025

